



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 01 сарын 15 өдөр

дугаар 810

Улаанбаатар хот

Г Резидент эмчийн албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, 48 дугаар зүйлийн 48.3.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам батлах тухай” 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Резидент эмчийн албан тушаалын тодорхойлолтын үлгэрчилсэн загварыг нэгдүгээр, хөдөлмөрийн гэрээний үлгэрчилсэн загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын хавсралтын дагуу резидент эмчийн ажлын байрны тодорхойлолтыг баталж, резидент эмчтэй хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллахыг эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтийг зохицуулж ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв /Б.Нарантуяа/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /П.Эрхэмбулган/, Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар /Д.Ганцэцэг/-т тус тус даалгасугай.



141210090

Эрүүл мэндийн сайдын
2021 оны 01. сарын 15. өдрийн
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

РЕЗИДЕНТ ЭМЧИЙН АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН
ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР

Дугаар.....

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- Төрийн албаны тухай хууль, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хууль хэрэгжиж эхэлсэн, Эрүүл мэндийн тухай хуулийн 47 дугаар зүйлд зааснаар хуулийн 25.4 дэх хэсгийг 2021.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхтэй холбогдуулан шинээр боловсруулсан.
- Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын 1.5 дахь заалт
- Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 09-ний A/226 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Резидент эмчийн ажиллах үлгэрчилсэн журмын 3.6.2 заалтын дагуу

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Эмнэлгийн тусlamж,
үйлчилгээний тухай хууль,
2016.04.22

Төрийн албаны тухай хууль,
2017.12.07

Эрүүл мэндийн тухай хуулийн 47
дугаар зүйл, 2016.04.22

Дагаж мөрдөх огноо: 2021.01.01

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: 2021.01 сар

Байгууллагын нэр:

Сургалт эрхлэх байгууллага

Албан тушаалын нэр:

Резидент эмч

1 өдрийн ажлын цаг:

8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн/хэвийн бус /сонгох/

Нэгжийн нэр:

Сургалтын алба

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

ТҮЭМ 4

Ажлын байрны албан ёсны байршил:

Харьяалах тасаг, нэгжийн нэр

Онцгой нөхцөл:

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго: Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг эмнэл зүйн стандарт, удирдамжийн дагуу эмнэл зүйн сургагч багшийн удирдлага дор үзүүлэх, өвчтөнд энэрэх сэтгэлээр хандан эмчийн ёс зүйг чандлан баримталж, бие даан тасралтгүй суралцах, дадлага эзэмшихэд оршино.

Албан тушаалын зорилт:

1. Тухайн үндсэн мэргэшлийн чиглэлээр оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамж, зааврын дагуу бие даан болон эмнэл зүйн сургагч багшийн удирдлага дор үзүүлэх
2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх
3. Эрдэм шинжилгээ, судалгаа, анагаахын шинжлэх ухааны олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг судлах, дүн шинжилгээ хийх, тасралтгүй бие даан суралцах
4. Байгууллагын дотоод үйл ажиллагаанд оролцох

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэл ийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, Оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – X Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрт тусгагдсан зайлшгүй эзэмших мэдлэг, чадварыг бие даан болон эмнэл зүйн сургагч багшийн удирдлага дор хийж гүйцэтгэх - Үйлчлүүлэгчийг тасаг, кабинетэд хүлээн авах, асуумж авах, үзлэг хийх - Эрүүл мэндийн бүртгэлийн маягт, холбогдох баримт бичгийг стандарт, зааврын хөтлөх, хянуулах - Өвчтөний биеийн байдал, эмчилгээний үр дүнг хянах, эмнэл зүйн сургагч багшийн удирдлага дор шаардлагатай шинжилгээг төлөвлөх, явцын дүгнэлт бичих, хянуулах - Tasag, нэгжийн тойрон үзлэгт оролцох - Өвчтөний эмнэл зүйн тохиолдлын танилцуулга бэлтгэх - Эмнэл зүйн сургагч багш, ахлах 	Ирц, идэвхи, оролцоо, багшийн дүн	Г Г,Т Г,Т Г,Т Г,Т Г,Т Г,Т Г,Т

	<p>дамжааны резидент эмчийг дагалдан жижүүр хийх</p> <ul style="list-style-type: none"> - Өвчтөний эрүүл мэндийн байдал, оношилгоо, эмчилгээ, үр дүн, эрсдэл, хүндрэлийн талаар өвчтөн, түүний ар гэрт энгийн, ойлгомжтой байдлаар тайлбарлах, зөвлөгөө өгөх - Эмнэлгийн бусад эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг, мэдээллээ хуваалцах, зөвлөлдөх, хамтран ажиллах - Хамтран суралцагч эмч, бусад эмнэлгийн мэргэжилтэнд заах замаар өөрийн мэдлэг үр чадвараа сайжруулах - Нийтийг хамарсан нөхцөл байдал үүсэх, халдварт өвчний цар тахал гарах, онц байдал, гамшигийн үеийн бэлэн байдал зарлагдсан тохиолдолд дайчлагдан ажиллах - Яаралтай тусламж, үйлчилгээнд оролцох 		Г,Т
	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн боловсрол олгох, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгаа хийх - Урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэг, оношилгоо эмчилгээнд оролцох - Эрүүл мэндийг дэмжих чиглэлээр тасаг, нэгжээс зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд оролцох 	Ирц, идэвхи, оролцоо, багшийн дүн	Г,Т
	<ul style="list-style-type: none"> - Суралцагчийн дэвтрэйг зааврын дагуу хөтөлж, сургалтын хөтөлбөрийг биелүүлсэн хугацаа, үнэлгээ, гардан үйлдлийн гүйцэтгэл бусад мэдээллийг тухай бүр бичиж тэмдэглэн, эмнэл зүйн сургагч багшаар баталгаажуулан, хянуулах, үнэлүүлэх - Бүтээлийн сан (Портфолио) хөтлөх - Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцох, илтгэл хэлэлцүүлэх - Мэргэжлийн болон эмгэг 	Ирц, идэвхи, оролцоо, багшийн дүн	Г
	<ul style="list-style-type: none"> - Суралцагчийн дэвтрэйг зааврын дагуу хөтөлж, сургалтын хөтөлбөрийг биелүүлсэн хугацаа, үнэлгээ, гардан үйлдлийн гүйцэтгэл бусад мэдээллийг тухай бүр бичиж тэмдэглэн, эмнэл зүйн сургагч багшаар баталгаажуулан, хянуулах, үнэлүүлэх - Бүтээлийн сан (Портфолио) хөтлөх - Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцох, илтгэл хэлэлцүүлэх - Мэргэжлийн болон эмгэг 		Г,Т

	<ul style="list-style-type: none"> - судлалын зөвлөгөөн, байгууллагын эмч нарын хуралд оролцох - Өөрийн мэдлэг ур чадвараа дээшлүүлэхийн тулд хэрэгцээт сургалтад хамрагдах - “Журнал клуб”-ын үйл ажиллагаанд оролцох - Мэргэжлийн ном, гарын авлага, аргачлал, эмнэл зүйн удирдамж, заавар боловсруулах, орчуулахад хамtran ажиллах 		Г
	<ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн ном, гарын авлага, аргачлал, эмнэл зүйн удирдамж, заавар боловсруулах, орчуулахад хамtran ажиллах 		Г,Т
	<ul style="list-style-type: none"> - Байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцох - Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, халдвартын сэргийлэлт, хяналт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг мөрдөн ажиллах - Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллах - Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь чанартай биелүүлэх 		Г,Т
<u>4 дүгээр зорилтын хүрээнд:</u>	<ul style="list-style-type: none"> - Байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд оролцох - Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал, халдвартын сэргийлэлт, хяналт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг мөрдөн ажиллах - Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдөж ажиллах - Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь чанартай биелүүлэх 		Г,Т

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр
Мэргэжил	Хүний их эмч, Шүдний их эмч/Нүүр ам судлалын их эмч, Уламжлалт анагаахын их эмч
Мэргэшил	-
Туршлага	-
Ур чадвар:	
Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - Тусlamж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах мэдээллийг цуглуулж, мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах, дүгнэх; - Шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх; - Мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах.
Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх; - Асуудлыг хууль болон ёс зүйн хэмжээнд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - Өөрийн чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, эмнэл зүйн сургагч багшид танилцуулах; - Асуудал шийдвэрлэх нийгэм, эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг тодорхойлоход суралцах, эмнэл зүйн

	<p>сургагч багштай хамтран ажиллах</p> <ul style="list-style-type: none"> - Албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх.
Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонгой хуваалцаж хамтран ажиллах; - Бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - Багаар ажиллах, багийн амжилтыг нэгжийн хамт олонд таниулах; - Бусдын санал, бодлыг нь сонсох, санал солилцох; - Ёс зүйгээр багийн хамт олноо манлайлах; - Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах; - Хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын хувьд бусдыг манлайлах.
Бусад	<ul style="list-style-type: none"> - Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах; - Албан хэрэг хөтлөх, баримт бичиг боловсруулах; - Монгол хэлний зөв бичгийн дүрэм, найруулга зүй, албан бичиг хөтлөлтийн стандартын мэдлэг, ур чадвартай байх; - Англи хэл эсхүл гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах чадвартай байх; - Компьютерын өргөн хэрэглээний программ бүрэн ашиглах чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ


Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Сургалтын албаны дарга

Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект: - Бусад тасаг, нэгжийн эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн бусад ажилтан
---	--

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Ажлын байрны тодорхойлолтыг баталсан		Ажлын байрны тодорхойлолттой танилцаж, зөвшөөрсөн
<p>Сургалт эрхлэх байгууллагын дарга /гарын үсэг/ тэмдэг ... оны....сар-ны өдөр</p>	<p>Сургалтын албаны дарга /гарын үсэг/ тэмдэг .. оны сар ...-ны өдөр</p>	<p>Резидент эмч /гарын үсэг/ нэрийн тэмдэг ... оны сар ...-ны өдөр</p>



Эрүүл мэндийн сайдын
2021 оны 01 сарын 15 өдрийн
дугаар тушаалын 2 дугаар хавсралт

РЕЗИДЕНТ ЭМЧИЙН ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭНИЙ ҮЛГЭРЧИЛСЭН ЗАГВАР
Дугаар.....

2021 оны сарын-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү Хөдөлмөрийн гэрээг /цаашид "гэрээ" гэх/ нэг талаас
нөөцийн албаны дарга _____ /Сургалт эрхлэх байгууллага/-ыг төлөөлж Хүний
талаас резидент эмч (цаашид "ажил олгогч" гэх) нөгөө
Хөдөлмөрийн тухай хууль, бусад хууль, тогтоомж, дүрэм журмыг баримтлан дор
дурьдсан нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

1.2. Гэрээний гол нөхцөл:

1.2.1. Ажлын байрны буюу албан тушаалын нэр: _____

1.2.2. Ажлын байрны тодорхойлолтод заасан ажил, үүрэг: _____

1.2.3. Үндсэн цалин буюу албан тушаалын цалингийн хэмжээ: _____

	Нэмэгдэл, нэмэгдэл хөлсний утга	Үндсэн цалингийн хувиар эсвэл төгрөгөөр буюу бусад хэлбэрээр
1.	Хөдөлмөрийн нөхцөл	
2.	Унааны хөлс	
3.	Хоолны мөнгө	
4.	Сүүний мөнгө	
5.	Бусад /илүү болон шөнийн цагийн хөлс гэх мэт/	

1.2.4. Хөдөлмөрийн нөхцөл: _____

1.3. Хөдөлмөрийн гэрээний хугацаа: _____ /Суралцан ажиллах хугацаагаар
байгуулна/.

1.4. Ажил амралтын цаг:

1.4.1. Өдрийн ажлын цаг нь хэвийн /хэвийн бус нөхцөлд 8.30 цагаас 17.00 цаг хүртэл (үргэлжлэх хугацаа 8 цаг) ажиллана.

1.4.2 Ажлын цагийг резидент эмч зөвхөн үүрэгт ажлаа бүрэн биелүүлэхэд зориулж, өөрийн бүх мэдлэг чадвар, мэргэжил, анхаарлаа дайчлан суралцаж, дадлага эзэмшин ажиллана.

1.4.3 Ажлын зайлшгүй шаардлага, захиргааны шийдвэрээр резидент эмчийг илүү цагаар ажиллуулж болно.

1.4.4 Нийтлэг эрх ашгийн үүднээс эрхэлж буй ажлаас өөр чиглэлийн ажилд ажлын болон ажлын бус цагаар түр хугацаагаар татан оруулах асуудлыг хоёр тал тохиролцон гүйцэтгэнэ.

1.4.5 Ээлжийн амралтыг Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйл, Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.7 дахь заалтыг үндэслэн олгоно.

Хоёр. Талуудын эрх, үүрэг

2.1. Ажил олгогч дараах эрх эдэлнэ:

2.1.1. Хууль тогтоомжид нийцүүлэн гэрээ байгуулан баталж, мөрдүүлэх;

2.1.2. Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам болон бусад холбогдох дүрэм, журмыг резидент эмчид танилцуулж, Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

2.1.3. Эрхэлсэн ажил үүргээ хугацаанд нь тогтсон дүрэм, журам, стандарт, холбогдох тушаал, шийдвэрийн дагуу чанартай гүйцэтгэж тайлагнахыг шаардах;

2.1.4. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, санал, санаачлага, идэвхи зүтгэлийг холбогдох журмын дагуу үнэлж, дүгнэх, урамшуулах;

2.1.5. Сахилгын хариуцлага хүлээлгэх нөхцөл бүрдсэн тохиолдолд Хөдөлмөрийн хууль, дотоод журам, гэрээнд зааснаар сахилгын шийтгэл ногдуулах;

2.1.6. Нийтийг хамарсан гамшигийн нөхцөл байдал үүсэх, халдварт өвчний цар тахал гарах, онц байдал, гамшигийн үеийн бэлэн байдал зарлагдсан тохиолдолд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр дайчлагдан ажиллуулах;

2.1.7. Урьдчилан мэдэх боломжгүй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажил олгогч нь гэрээнд заагаагүй өөр ажилд түр хугацаагаар шилжүүлэх;

2.1.8. Гэрээ цуцлагдах нөхцөл байдал бий болсон үед Резидент эмч ажлаа зохих ёсоор хүлээлцээгүй бол цалин хөлсийг олгохгүй байх;

2.1.9. Хуулиар олгогдсон бусад эрх.

2.2. Ажил олгогч дараах үүрэг хүлээнэ:

2.2.1. Энэхүү гэрээгээр тохиролцсон ажлын байраар хангах, ажиллан суралцах нөхцөл бүрдүүлэх, эмнэл зүйн сургагч багшийг томилох, тасаг, нэгжид хуваарилах;

2.2.2. Хөдөлмөрийн үр дүнд тохирсон цалин, нэмэгдэл хөлсийг гэрээнд заасан хугацаанд тогтмол олгох;

2.2.3. Ажил үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай ажлын байрны тоног төхөөрөмж, ширээ сандал, бичгийн хэрэгсэл, мэдээ, мэдээлэл зэрэг бусад нөхцөлөөр хангах;

2.2.4. Резидент эмчийн үйлчилүүлэгчид бие даан үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтыг Мэргэжлийн салбар зөвлөлөөс баталсан жагсаалт, үндсэн мэргэшлийн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй нийцүүлэн тухайн суралцагчийн ажиллах хугацаанд батлах;

2.2.5. Резидент эмчид Хөдөлмөрийн дотоод журам, гэрээнд зааснаар туслалцаа, дэмжлэг үзүүлэх;

2.2.6. Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхэд нь туслалцаа, дэмжлэг үзүүлэх;

2.2.7. Резидент эмчээс гаргасан шинэ санал, санаачлага, бүтээлч байдлыг дэмжиж ажиллах;

2.2.8. Резидент эмчийг хамгаалах хувцас хэрэгсэл, гарын авлага, хөтөлбөр, суралцагчийн дэвтэрээр хангах;

2.2.9. Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6-д заасны дагуу резидент эмчийг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ болон дархлаажуулалтад үнэ төлбөргүй хамруулах;

2.2.10. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ, эмчилгээ, оношилгооны стандарт, заавар, халдварт хамгааллын дэглэмийг мөрдөх, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг резидент эмчээс шаардах, гэрээний биелэлтийг дүгнэх, урамшуулах, хариуцлага тооцох;

2.2.11. Резидент эмчийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, судалж шийдвэрлэх, холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх;

2.2.12. Хуульд заасан бусад үүрэг.

2.3 Резидент эмч дараах эрх эдэлнэ:

2.3.1. Аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн хөдөлмөрийн нөхцлөөр хангуулах;

2.3.2. Гэрээгээр тохиролцсон цалин, хөлс, нэмэгдэл хөлс авах;

2.3.3. Хөдөлмөрийн хууль, түүнд нийцүүлэн гаргасан Хөдөлмөрийн дотоод болон бусад журам, гэрээнд зааснаар ажиллах, амрах, туслалцаа дэмжлэг авах;

2.3.4. Хууль тогтоомжид заасны дагуу тэтгэмж авах;

2.3.5. Өөрийн ажлын үр дүнг үнэлүүлэх улмаар төр засаг, салбар, байгууллагын шагналд нэрээ дэвшүүлэх, мөнгөн урамшуулал авах;

2.3.6. Эрдэм шинжилгээний ажил эрхлэх;

2.3.7 Сургалт эрхлэх байгууллагатай үндсэн мэргэшлийн сургалтын хугацаагаар хөдөлмөрийн гэрээ байгуулах, суралцах орчин нөхцөл, хамгаалах хувцас хэрэглэлээр хангуулах;

2.3.8 Үндсэн мэргэшлийн сургалтад суралцан ажиллах хугацаанд Эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6-д заасны дагуу эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ болон дархлаажуулалтад төлбөргүй хамрагдах;

2.3.9 Сургалтын үйл ажиллагаатай холбоотой аливаа санал, хүсэлт, гомдлыг гаргах, шийдвэрлүүлэх, хариу авах;

2.3.10. Хууль, дүрэм, журам, стандарт нь хэрэгжих боломжгүй, үйлчлүүлэгчийн эрх ашигт нийцэхгүй байгаа тохиолдолд түүнийг өөрчлүүлэх тухай саналаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу ажил олгогчид тавих;

2.3.11 Хуулиар олгогдсон бусад эрх, баталгаа.

2.4 Резидент эмч дор дурдсан үүрэг хүлээнэ:

2.4.1. Гэрээнд заасан ажил, үүргээ гүйцэтгэхдээ мэдлэг чадвараа дайчлан үнэнч шударгаар ажиллан, ажлын цагийг үр бүтээлтэй өнгөрүүлж, хамт олны дунд ажил хэрэгч, нөхөрсөг эвсэг харьцааг эрхэмлэх;

2.4.2. Сургалт эрхлэх байгууллагын даргын шийдвэрээр томилогдсон эмнэл зүйн сургагч багшаар удирдуулан, хуваарилагдсан тасаг, нэгжид ажиллах;

2.4.3. Ажил олгогчоос баталж мөрдүүлж буй Хөдөлмөрийн дотоод болон бусад журам, ёс зүйн дүрмийг сахин биелүүлэх, төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэж чанд мөрдөн ажиллах;

2.4.4. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцох, илтгэл мэдээлэл хэлэлцүүлэх, мэдлэг мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх;

2.4.5. Нийтийг хамарсан гамшигийн нөхцөл байдал үүсэх, халдварт өвчний цар тахал гарах, онц байдал, гамшигийн үеийн бэлэн байдал зарлагдсан тохиолдолд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр дайчлагдан ажиллах;

2.4.6. Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хүний эрхийг хангах, гэмт хэрэг, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;

2.4.7. Сонор сээрэмжтэй байж, ажлын байрны аюулгүй ажиллагаанд анхааран, хөдөлмөр хамгааллын шаардлагыг дагаж ажиллах, хариуцаж буй тоног төхөөрөмж, машин техник, хэрэгслийн дүрэм зааврыг чанд мөрдөх, болзошгүй аюулаас сэргийлэх;

2.4.8. Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад амь нас, эрүүл мэндэд онц аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажлаа зогсоож энэ тухайгаа эмнэлзүйн сургагч багшид мэдэгдэх;

2.4.9. Байнга хийгддэг олон дахин давтагддаг үйлдлүүдэд (ажилд) эрсдэлтэй ажил, хэвийн бус болон яаралтай, онцгой нөхцөл, тохиолдолд ажиллах зааварчилгаа, хяналтын хуудсыг ажилдаа нэвтрүүлж, аливаа эрсдэл, алдаа гарахаас өөрийгөө болон хамт олноо сэргийлж ажиллах;

2.4.10. Бүртгэлээр хариуцуулсан үндсэн хөрөнгийн бүрэн бутэн байдлыг хянаж, хайрлан хамгаалж, тэдгээрийг үр ашигтай зарцуулах, өөрийн буруугаас эвдэж гэмтээсэн, алдаж үрэгдүүлсэн бол байгууллагаас тогтоосон үнийн дүнгээр төлж, хохиролгүй болгох;

2.4.11. Төрийн болон байгууллагын нууцын тухай хууль болон хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг хадгалах;

2.4.12. Ажил, мэргэжлийн ур чадвар, гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэхэд анхаарч ажиллах;

2.4.13. Сургалтаас гарах тухай хүсэлтийг нэг сараас доошгүй хугацааны өмнө ажил олгогчид бичгээр өргөдөл гарган албан ёсоор мэдэгдэх;

2.4.14. Энэхүү гэрээнд зааснаас гадна ажил олгогчоос өгсөн хуульд нийцсэн бусад шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх.

Гурав. Хөдөлмөрийн сахилга, эд хөрөнгийн хариуцлага

3.1 Хөдөлмөрийн гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, байгууллагын баталсан Хөдөлмөрийн дотоод журмыг зөрчсөн резидент эмчид Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлд заасанчлан дор дурдсан хэлбэрийн сахилгын шийтгэл ногдуулна. Үүнд:

3.1.1. "сануулах" сахилгын шийтгэлд:

- Ажлын цагийг үр ашиггүй өнгөрүүлэх, ажлын цагаар сэлгүүцэх;

- Хүндэтгэх шалтгаангүйгээр ажлын нэг сарын хугацаанд ажлаас хоцорсон (нийлбэр нь нэг өдөр), эсвэл нэг өдрийн ажил таслах;

- Үйлчлүүлэгч болон нас барагчийн ар гэрээс ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой гаргасан өргөдөл, гомдол үндэслэлтэй нь нотлогдсон;

3.1.2. "үндсэн цалинг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах" сахилгын шийтгэлд:

- Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хоёр өдрийн ажил таслах;

- Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгаагаар хоёр ба түүнээс дээш удаа хангалтгүй үнэлгээ авсан бол;
- Төлөвлөгөөт болон цаг үеийн үзлэг, шалгалт болон хөндлөнгийн хяналт шалгалтаар хариуцан ажиллаж буй албаны үйл ажиллагаа нь хангалтгүй үнэлэгдэх;
- Албан үүргээ хоёр ба түүнээс дээш удаа хангалтгүй биелүүлсэн бол.

3.1.3. “Сургалтаас хасах, ажлаас халах” сахилгын шийтгэлд:

- Эмчилгээ, оношилгоо, эмгэг судлалын тусламж, үйлчилгээтэй холбоотой дүрэм, журам, стандарт, зааврыг ноцтой зөрчих;
- Мэргэжлийн алдаа гаргаж, хүний амь нас, эрүүл мэндийг хохироосон нь хууль хяналтын байгууллагаар тогтоогдсон;
- Ажлын байранд (албан үүргээ гүйцэтгэж байгаа бүх нөхцөл) согтууруулах ундаа, согтуурсан, мансууруулах бодис хэрэглэх;
- Байгууллагын болон хувь хүний эрүүл мэндтэй холбоотой нууцыг задруулах, түгээх;
- Байгууллагын эд хөрөнгийг дур мэдэн авч гарах, завдах, завших, ашиг олгох зорилгоор хэрэглэх;
- Байгууллагын нэр хүндийг гутаах, санаатайгаар унагах зэргээр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд үндэслэлгүйгээр түгээх;
- Сахилгын зөрчлийг давтан гаргасан;
- Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/226 дугаар тушаалаар баталсан “Резидент эмчийн ажиллах үлгэрчилсэн журамыг зөрчсөн бол.

Дөрөв. Гэрээг өөрчлөх, дуусгавар болгох

- 4.1 Хөдөлмөрийн тухай хуулийн 32-34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр ажил олгогчийн санаачлагаар энэхүү гэрээг түр өөрчилж болно.
- 4.2 Хөдөлмөрийн тухай хуулийн 37-40 дүгээр зүйлд заасан үндэслэлээр энэхүү гэрээг дуусгавар болгоно.
- 4.3 Гэрээ байгуулагч хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

Тав. Бусад зүйл

- 5.1 Энэхүү гэрээнд тусгагдаагүй асуудлыг Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль эрх зүйн актаар зохицуулна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

АЖИЛ ОЛГОГЧ:

Ургийн овог:
Эцэг/эхийн нэр:
Хүний нөөцийн албаны даргын нэр:
Утас:
Хаяг:

Гарын үсэг: _____
ТЭМДЭГ

..... оны сарын-ны өдөр

РЕЗИДЕНТ ЭМЧ:

Ургийн овог:
Эцэг/эхийн нэр:
Резидент эмчийн нэр:
Утас:
Хаяг:

Гарын үсэг: _____
НЭРИЙН ТЭМДЭГ

..... оны сарын-ны өдөр